



## МОНГОЛ КУВЕЙТЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВ ТӨААТҮГ-ЫН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Аудитын код: САГ-2018/120/СТА-ТӨҮГ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663  
Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер Г.Гүнжидмаа  
Утас: 261885  
Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Аудитор Г.Мөнхчимэг  
Утас: 261740  
Цахим хаяг: [munkhchimegg@audit.gov.mn](mailto:munkhchimegg@audit.gov.mn)

Ай Жэй Эй Эйч аудит ХХК-ийн захирал Г.Энхмаа  
Утас: 99040059 450279  
Цахим хаяг: [Enkhmaa\\_56@yahoo.com](mailto:Enkhmaa_56@yahoo.com)

Чанарын хяналтын мэргэжилтэн Л.Оюунцэцэг  
Утас: 99073014  
Цахим хаяг: [oyuntsetsegl@yahoo.com](mailto:oyuntsetsegl@yahoo.com)

Аудитор Г.Бэлэгт  
Утас: 99088333  
Цахим хаяг: [g\\_belegt@yahoo.com](mailto:g_belegt@yahoo.com)

Улаанбаатар хот



## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2	Аудитын тайлан .....	5
2.1	Оршил .....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.5	Дотоод хяналт .....	7
2.6	Зорилтот түвшний талаарх тайлбар, тодруулга.....	4
2.7	Шилэн дансны мэдээлэл .....	8
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	9
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	9
2.9.1	Авлага, өр төлбөрийн талаар.....	9
2.9.2	Үндсэн хөрөнгийн талаар .....	9
2.9.3	НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх тухай.....	10
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....	10
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	10
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: .....	10
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
3.1	Авлага, өр төлбөрийн талаар .....	12
3.2	үндсэн хөрөнгийн талаар .....	13
3.3	НӨАТ-ын төлөгчөөр бүртгүүлэх тухай .....	14
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	15
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	17
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	19





**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ КУВЕЙТЫН БАЙГАЛЬ  
ХАМГААЛАХ ТӨВ ТӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Ч.БАТЖАРГАЛ ТАНАА

2018.03.15 № 06/740  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kheregi\Yawsan\_Bichig\2018\0315SAG67.Docx

071172

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**Үүрэг, хариуцлага**

Байгууллагын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. М* Ц.НАРАНЧИМЭГ



\\10.10.10.20\Bichig\_Kherel\Yawsan\_Bichig\2018\0315SAG67.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## 1 Аудитын тайлан

### 1.1 Оршил

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын захирал Ч.Батжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн бараа материалыг бодит үнэ цэнээр тооцох, зөрүүтэй авлагыг залруулах, СТОУС-ын шинэчлэлийг хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан, аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага


Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 2-ноос 2018 оны 3 дугаар сарын 13-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, компанийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-ийн чанарын хяналтын менежер Л.Оюунцэцэг, аудитор Г.Бэлэгт, аудиторын туслах Я.Чинцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2018 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 08 тоот албан бичгээр Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-д ирүүлсэн байна.

### 1.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж ажиллаж байна.


Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ нь Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 100 тоот тогтоолоор байгуулагдсан. 2007 онд Монгол болон Кувейт улсын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд Кувейт улсын Засгийн газрын 100 хувийн санхүүжилтээр баригдсан. Түүнээс хойш 2010 онд тус төвийн объект ашиглалтад орсон бөгөөд “Монгол Кувейтын судалгааны төв” төрийн бус байгууллага /ТББ/ болсон байна. Улмаар тус төвийн объектыг Монгол Улсын өмчлөлд шилжүүлж 2016 онд “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” хэмээн нэрийг нь өөрчилж, статусыг нь ТББ байсныг ТӨААТҮГ болгожээ.

### Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын эрхэм зорилго

Байгаль хамгаалал, нэн ховор ан амьтан ургамал хамгаалах, хөрс ус агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх, байгаль орчин аялал жуулчлалын чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, эко аялал жуулчлалыг хөгжүүлэх юм.

### Үйл ажиллагааны стратегийн зорилт

- Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, удирдлагын манлайлал, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах замаар үйлчилгээ, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх, дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Хүрээлэн буй орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаархи хууль тогтоомжинд нийцүүлэн ажиллах
- Ойг нөхөн сэргээх, ойжуулах, тарьц, суулгац ургуулах, ойн гарцыг нэмэгдүүлэх арга технологийг нэвтрүүлэх, хөрс, ус судлалын лаборатори байгуулж, өөрийн эзэмшлийн талбайд туршилт судалгааны ажил хийх
- Эко аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд мэдээллийн нэгдсэн системтэй болгож, амрагч үйлчлүүлэгчдэд хүндрэлгүй түргэн шуурхай үйлчлэх



- Бодлогын хэрэгжилтийн явц, салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төлөвлөлт, гүйцэтгэл, үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх гэж зорилтоо тодорхойлсон байна.

### Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

- Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын бодлого, стратегийг эдийн засаг, санхүүгийн нөөц, олон улсын хамтын ажиллагааны бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх
- Байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг дэмжих
- Байгууллагын албан хаагчдын эко аялал жуулчлалын талаарх мэдлэгийг дээшлүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлэх шинжлэх ухааны ололт, олон улсын тэргүүний арга туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх
- Байгаль орчныг хамгаалах, эко системийн тэнцвэрт байдлыг хадгалахтай холбогдуулан үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээнд шинжлэх ухааны ололт, ногоон технологи нэвтрүүлэх гэж тодорхойлсон байна.

#### 1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, аж ахуйн нэгж байгууллагын мөрддөг татварын хуулиудийг шалгуур болгон ашиглалаа.


Аудитаар Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Ноён” програм хангамжаар бэлтгэсэн байна.

#### 1.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.



Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалттай гэж үзлээ.

## 2.6 Зорилтот түвшний талаарх тайлбар, тодруулга

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 313 дугаар тогтоолоор зорилтот түвшнийг баталсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 408.0 сая төгрөгөөр, үндсэн бус үйл ажиллагааны орлогыг 168.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 565.6 сая төгрөгөөр, татварын өмнөх ашгийг 10.4 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 9.4 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

### 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АУДИТ ХИЙГДСЭН ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ


Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Өмнөх оны гүйцэтгэл	2017 он		Өөрчлөлт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү (3-2)	Хувь (3*100/2)
А	Б	1	2	3	4	5
<b>Нийт орлого:</b>	<b>мян/төг</b>	<b>61,882.4</b>	<b>576,000.0</b>	<b>341,525.5</b>	<b>(234,474.5)</b>	<b>59.3</b>
Цэвэр борлуулалт	мян/төг	53,382.4	408,000.0	341,055.7	(66,944.3)	83.6
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг				92,713.6		
Үйл ажиллагааны бус орлого	мян/төг	8,500.0	168,000.0	469.8	(167,530.2)	
<b>Нийт зардал:</b>	<b>мян/төг</b>	<b>61,257.3</b>	<b>565,606.6</b>	<b>525,734.9</b>	<b>(39,871.7)</b>	<b>93.0</b>
Үйл ажиллагааны зардал	мян/төг	61,257.3	565,606.6	525,434.9	(40,171.7)	92.9
Үйл ажиллагааны бус зардал	мян/төг			300.0	300.0	
Үүнээс: Удирдлагын зардал	мян/төг	42,954.3	345,970.9	202,138.7	(143,832.2)	
Татварын өмнөх ашиг / алдагдал /	мян/төг	625.1	10,393.4	(184,218.1)	(194,611.5)	(1,772.5)
<b>Цэвэр ашиг / алдагдал /</b>	<b>мян/төг</b>	<b>562.6</b>	<b>9,353.9</b>	<b>(184,218.1)</b>	<b>(193,572.0)</b>	<b>(1,969.4)</b>
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	Төгрөг	0.99	0.98	1.54	0.56	156.8
Нийт авлага	мян/төг					
Нийт өр төлбөр	мян/төг					
Хөрөнгө оруулалт, их засвар	мян/төг				-	
Ажиллагсдын тоо	хүн /тоо	8.00	8.0	8.0	-	100.0

Тайлант оны гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 341.0 сая төгрөг, хүүгийн орлого болон валютын ханшийн олз 0.1 сая төгрөг, бусад орлого 0.4 сая төгрөг, нийт 341.5 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 92.7 сая төгрөг, борлуулалт маркетингийн зардал 263.7 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардал 169.0 сая төгрөг, бусад зардал 0.3 сая төгрөг нийт 525.7 сая төгрөгийн зардал, 0.01 сая төгрөгийн татварын зардалтай, 184.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Алдагдлын 178.6 сая төгрөг буюу 96.9 хувь нь элэгдлийн зардал байна.

## 1.7 Шилэн дансны мэдээлэл

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ нь шилэн дансны тухай хуульд заасны дагуу зохих хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны цахим хуудас нь дотроо:





1. Хөрөнгө оруулалт, Тендер, Худалдан авалт
2. Бусад мэдээлэл гэсэн үндсэн 2 бүтэцтэй байна.

Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын хэсэгт:

1. Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөг бүтэн жилээр байршуулсан.
2. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг тендер зарлагдсан тухай бүр байршуулсан.
3. Концессийн мэдээллийг оруулсан
4. Худалдан авах ажиллагааны тайланг бүтэн жилээр байршуулсан.

Бусад мэдээлэл:

1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг сар бүр байршуулсан.
2. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллийг сар бүр байршуулсан.
3. Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээллийг сар бүр байршуулсан.

### **1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар**

Аудитын төлөвлөгөөний дагуу 6 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

### **1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл**


#### **1.9.1 Авлага, өр төлбөрийн талаар**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 183 тоот тогтоолоор баталсан байгууллагын эхлэлтийн балансад хариуцах эзэн нь тодорхойгүй 53.2 сая төгрөгийн авлага шилжиж ирсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Уг авлагын эзэн холбогдогчийг тогтоох, шийдвэрлэх арга хэмжээ авах зөвлөмж өгөв.

#### **1.9.2 Үндсэн хөрөнгийн талаар**

ТББ-аас шилжиж ирсэн үндсэн хөрөнгөнд 254.5 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа боловч тээврийн хэрэгслийн гэрчилгээг байгууллагынхаа нэрдээр шилжүүлээгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Тээврийн хэрэгслийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлж авах зөвлөмж өгөв.

### 1.9.3 НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх тухай

Тус байгууллагын 2017 оны жилийн борлуулалтын орлого нь НӨАТ төлөх хэмжээнд хүрсэн боловч нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлээгүй байна. Шийдвэрлэсэн нь: Харьяа татварын албанд хүсэлт гаргаж нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлэх зөвлөмж өгөв.

### 1.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татах чухал асуудал гараагүй болно.

### 1.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал үгүй болно.

### 1.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 307.7 сая төгрөгийн **материаллаг бус алдаа** зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

### 1.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2016 оны 10 дугаар сард байгуулагдсан тул тухайн оны санхүүгийн тайланд аудит хийгдээгүй байна.

### 1.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2017 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 525.7 сая төгрөг бөгөөд 2 хувиар материаллаг байдлыг тодорхойлж, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 10.5 сая төгрөгөөр баталгаажууллаа.

### 1.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шуударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

## 2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



**2.1 Авлага, өр төлбөрийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 183 тоот тогтоолоор баталсан байгууллагын эхлэлтийн балансад хариуцах эзэн нь тодорхойгүй 53.2 сая төгрөгийн авлага шилжиж ирсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.3. “Жинхэнэ хэрэгжилтийн” 5.1.5. “Хэмжигдэхүйц байх” гэж заасантай нийцэхгүй байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Уг авлагын эзэн холбогдогчийг тогтоох, шийдвэрлэх арга хэмжээ авах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 07 сарын 02-нд үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Эрсдэлүүд**

Төлөгдөх найдваргүй өр авлага бүртгэл тайланд тусгагдаж, байгууллагын эдийн засгийн зохистой харьцааг бууруулах, холбогдох батламж мэдэгдлүүд зөрчигдөх,

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын үйлчлүүлэгчийн санхүүгийн танилцуулсан болно. бүртгэлийг удирдлага, ажилтанд



**2.2 ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

ТББ-аас шилжиж ирсэн үндсэн хөрөнгөнд 254.5 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа боловч тээврийн хэрэгслийн гэрчилгээг байгууллагынхаа нэр дээр шилжүүлээгүй байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн “Үнэн зөв” байх батламж мэдэгдлийг зөрчиж байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Тээврийн хэрэгслийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлж авах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 07 сарын 02-нд үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Эрсдэлүүд**

Үнэн зөв байх батламж мэдэгдэл, зөрчигдөх

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**2.3 НӨАТ-ЫН ТӨЛӨГЧӨӨР БҮРТГҮҮЛЭХ ТУХАЙ**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

Тус байгууллагын 2017 оны жилийн борлуулалтын орлого нь НӨАТ төлөх хэмжээнд хүрсэн боловч нэмэгдсэн өртгийн татвар төлөгчөөр бүртгүүлээгүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий дараах этгээд албан татвар суутган төлөгч байна”, 5.2.1-т “Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил, үйлчилгээний борлуулалт хийсэн”, 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 4.1.19-д заасны дагуу албан татвар суутгах үүрэг үүссэн хувь хүн, хуулийн этгээд ажлын 10 өдөрт багтаан албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх өргөдлөө харьяалах татварын албанд гаргана” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Эрсдэлүүд**

Холбогдох хууль тогтоомж зөрчигдөх

**ҮАГ-ын зөвлөмж**

Харьяа татварын албанд хүсэлт гаргаж нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлэх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 07 сарын 02-нд үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.




**3 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН****3.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

1	ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	13,296,334.30	9,299,119.10
1.1.2	Дансны авлага	64,036,150.00	59,875,337.12
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага	6,962,266.14	3,443,828.14
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	57,094,640.27	110,524,204.14
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	454,750.00	
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>141,844,140.71</b>	<b>183,142,488.50</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	7,947,162,793.27	7,706,537,473.22
1.2.2	Биет бус хөрөнгө	1,980,000.00	1,633,500.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>7,949,142,793.27</b>	<b>7,708,170,973.22</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,090,986,933.98</b>	<b>7,891,313,461.72</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	3,263,500.00	14,744,100.00
2.1.1.2	Цалингийн өглөг	229,288.52	238,356.50
2.1.1.3	Татварын өр	21,910,259.63	5,406,686.44
2.1.1.4	НДШ-ийн өглөг	2,927,866.63	0.21
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	9,473,600.00	1,960,000.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>37,804,514.78</b>	<b>22,349,143.15</b>



<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>37,804,514.78</b>	<b>22,349,143.15</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч : - төрийн	8,057,023,860.11	8,057,023,860.11
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(3,841,440.91)	(188,059,541.54)
2.3.10	Тайлант үеийн ашиг		(184,218,100.63)
	Өмнөх үеийн ашиг	(3,841,440.91)	(3,841,440.91)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>8,053,182,419.20</b>	<b>7,868,964,318.57</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,090,986,933.98</b>	<b>7,891,313,461.72</b>





**3.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	<b>ҮЗҮҮЛЭЛТ</b>	<b>2016 оны 12-р сарын 31</b>	<b>2016 оны 12-р сарын 31</b>
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>178,290,900.00</b>	<b>341,055,650.00</b>
2	Борлуулалтын өртөг	44,093,657.51	92,713,561.55
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>134,197,242.49</b>	<b>248,342,088.45</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	46,609.79	86,547.43
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	1,576,000.00	352,800.00
	Орлогын дүн		
9	Борлуулалт, маркетингийн зардал		263,687,832.93
10	Ерөнхий ба удирдлагын зардал	139,656,632.21	169,033,504.26
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		300,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		30,455.42
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(3,836,779.93)</b>	<b>(184,209,445.89)</b>
19	Орлогын татварын зардал	4,660.98	8,654.74
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(3,841,440.91)</b>	<b>(184,218,100.63)</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(3,841,440.91)</b>	<b>(184,218,100.63)</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>-</b>	<b>-</b>
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(3,841,440.91)</b>	<b>(184,218,100.63)</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		



**3.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>8,057,023,860.11</b>	<b>(3,841,440.91)</b>	<b>8,053,182,419.20</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>8,057,023,860.11</b>	<b>(3,841,440.91)</b>	<b>8,053,182,419.20</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-
5	Бусад дэлгэрэнгүй орлого			-
6	Өмчид гарсан өөрчлөлт			-
7	Зарласан ногдол ашиг			-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
9	<b>2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>8,057,023,860.11</b>	<b>(3,841,440.91)</b>	<b>8,053,182,419.20</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-	-
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>			-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(184,218,100.63)	(184,218,100.63)
13	Бусад дэлгэрэнгүй орлого			-
14	Өмчид гарсан өөрчлөлт			-
15	Зарласан ногдол ашиг			-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
17	<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>8,057,023,860.11</b>	<b>(188,059,541.54)</b>	<b>7,868,964,318.57</b>



### 3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/төгрөгөөр/	
	ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>169,116,985.58</b>	<b>334,822,246.11</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	168,953,375.79	334,698,750.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		43,386.00
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	163,609.79	80,110.11
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>130,385,929.30</b>	<b>334,513,474.05</b>
	Ажиллагчдад төлсөн	24,931,383.45	105,097,128.92
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,992,232.06	32,528,831.01
	Бараа материал худалдан авахад төлсөн	52,825,756.48	38,787,884.57
	Ашиглалтын зардалд төлсөн	41,953,319.31	71,050,367.05
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,292,309.00	12,996,635.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн		9,375,300.00
	Даатгалын төлбөрт төлсөн		89,100.00
	Бусад мөнгөн зарлага	4,390,929.00	64,588,227.50
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>38,731,056.28</b>	<b>308,772.06</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	<b>60,437.32</b>
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		60,437.32
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>8,546,690.00</b>	<b>4,396,880.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,546,690.00	4,396,880.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(8,546,690.00)</b>	<b>(4,336,442.68)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		10,100,000.00

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ  
10,130,435.42

	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
	Бусад орлого		30,455.42
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>31,895,136.00</b>	<b>10,100,000.00</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	31,895,136.00	10,100,000.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(31,895,136.00)	<b>30,455.42</b>
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<b>(1,710,769.72)</b>	<b>(3,997,215.20)</b>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,007,104.02	13,296,334.30
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,296,334.30	9,299,119.10

